

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР
ИЛТГЭХ ХУУДАС**

**"ЭХ ОРОНЧ ДАРХАНЫ ИРЭЭДҮЙ" ӨДӨРЛӨГИЙН ХҮРЭЭНД ӨСВӨР ҮЕ, ХҮҮХЭД
ЗАЛУУСТ ЗОРИУЛСАН "ЭХ ОРОНЧ ҮЗЛИЙГ ТӨЛӨВШҮҮЛЭХ НЬ" УРИАН ДОР ЗОХИОН
БАЙГУУЛСАН ТУХАЙ**

2024.05.20

Дархан-Уул аймаг

Хүүхэд, залуучуудад эх орноороо бахархах, итгэл үнэмшилтэй, биеэ зөв авч явах, багаар ажиллах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, амьдралын зөв дадал, чадварыг эзэмшүүлэх зорилгоор "ЭХ ОРОНЧ ДАРХАНЫ ИРЭЭДҮЙ" арга хэмжээний хүрээнд 2024 оны 05 дугаар сарын 08-наас 12-ны өдрийг хүртэлх хугацаанд Залуучууд театрт **"Эх оронч үзлийг төлөвшүүлэх нь"** уриатай Дархан-Уул аймгийн ЗДТГ, Цэргийн штаб, аймгийн Соёл, урлагийн газар, Гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Залуучууд театр, Төв номын сан, Хүүхдийн номын ордон зэрэг байгууллагууд зохион байгууллаа. Тус өдөрлөгийг 11:00 цагаас 15:00 хүртэл "Найрамдал талбай"-д зохион байгуулж нийт 435 ахлах ангийн сурагчид хамрагдлаа.

Зохион байгуулсан үйл ажиллагаа:

1. "Эх оронч Дарханы ирээдүй" өдөрлөгийг зохион байгуулах хөтөлбөрийг боловсруулж Гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын даргаар батлуулж нээлтийн үеэр лед үйл ажиллагааны фото зургийг дарж ажиллалаа.
 2. "Найрамдал талбай"-д 11:00-15:00 цаг хүртэл
 - Аймгийн Төв номын сангийн зүгээс "Монгол цэргийн өдөр" сэдэвчилсэн номын үзэсгэлэнг гаргаж, уншигчийн үнэмлэх нээж, ном солилцоо хийлээ. Мөн "Ном хож" асуулж хариултын буланг ажиллуулж 32 хүүхдийг урамшуулав. Мөн танин мэдэхүй "АХА" хөгжөөнт тэмцээнийг зохион байгуулж 125 хүүхдийг хамруулав.
 - Залуучууд театр нь өдөрлөгийн нээлтийн үеэр эх орны тухай дуу, морин хуурын эгшгийг эгшиглүүлж урлагийн тоглолтыг толилууллаа. Мөн сурагчдын дунд "Эх орон"-ы тухай дууны уралдааныг 5 хоногийн турш зохион байгуулж 48 хүүхдийг хамруулж шагнаж урамшуулав.
 - Хүүхдийн номын ордноос "Эх оронч Дарханы ирээдүй" өдөрлөгийн хүрээнд "Өв соёлоо мэдье" боловсролын хөтөлбөр, "Эх орон"-ы сэдэвт сэдэвчилсэн номын үзэсгэлэн, Угийн бичгийн сургалт танилцуулгыг тус тус зохион байгуулж 165 хүнийг хамруулсан.
 - Аймгийн цэргийн штабаас "Эх орон"-ы сэдэвт сэдэвчилсэн үзэсгэлэн, фото зон, техник төхөөрөмжтэй танилцах хөтөлбөрийг зохион байгуулж 65 хүнийг хамруулсан.
- Үйл ажиллагааны мэдээг Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газар цахим хуудас болон салбар байгууллагууд өөрийн цахим хуудсуудад мэдээлэл нийтэлж ажиллалаа.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР